

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ  
11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн бүрэн эрхийн анхдугаар хуралдаан 2020 оны 11-р сарын 03-ны өдөр 100 хувийн ирцтэй хуралдаж аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийг сонгосон. 11-р сарын 09-ний өдөр Тэргүүлэгчид хуралдаж Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай асуудал, 11-р сарын 18-ны өдөр цахимаар хуралдаж аймгийн ИТХ-ын ээлжит 2 дугаар хуралдааны товыг хэлэлцэж 2020 оны 12-р сарын 03-ны өдрийн 11.00 цагт хуралдуулахаар шийдвэрлэсэн байна.

Мөн 11-р сарын 27-ны өдөр Тэргүүлэгчдийн 3 дугаар хуралдаан хуралдаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилох тухай, аймгийн ИТХ-ын ээлжит хоёрдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлын тухай, аймгийн ИТХ-ын ээлжит хоёрдугаар хуралдааныг цахимаар хуралдуулах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн даргын 2020 оны 10-р сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор томилогдсон ерөнхий шалгалт зохион байгуулах салбар комисс Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2020 оны 11-р сарын 06-ны өдрөөс 09-ний өдрүүдэд зохион байгуулсан. Архангай аймгийн хэмжээнд 332 иргэн шалгалт өгөхөөр бүртгүүлснээс, 236 иргэн шалгалтад орж, 9.7 хувь буюу 70 иргэн Ерөнхий мэдлэг, монгол хэл бичиг, дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад тэнцсэн байна.

Аймгийн Онцгой комисс, улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу 11-р сарын 11-нээс 14-ний өдөр хүртэл, мөн энэ хугацааг 12-р сарын 01-ний өдөр хүртэл сунгаж, аймгийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна.

**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТООН МЭДЭЭЛЭЛ**

/2020 оны 11-р сарын 27-ны өдрийн байдлаар/



Коронавируст халдварын цар тахлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, байгууллагынхаа ажилчдын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах зорилгоор аймгийн Онцгой комиссоос төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын дарга нарт зөвлөмжийн дагуу цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг өдөрт 3-аас доошгүй хийх, албан хаагчид амны хаалт хэрэглэх, гар угаах, ундны цэвэр халуун усаар хангах, банкууд халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, зай барих нөхцөлийг бүрдүүлэх, эцэг, эхийн үүргээ ухамсарлаж, хүүхдээ өөрсдийн хараа хяналтад байлгах, гэр бүлдээ зөвлөгөө өгөх, голомтод орон нутагт зорчсон ажилтан байгаа бол гэртээ тусгаарлан, өрхийн болон сумын эмчийн хяналтад байж, онлайн аргаар ажлаа хийх, алба хаагчид утсаар байнга нээлттэй байлгах, байгууллагын алба хаагчдыг үнэмлэхжүүлэх, ажилчдын цагийн хуваарь, ээлжийг тодорхой болгох зэрэг 11 чиглэлийн үүргийг өгөн ажиллаж байна.

11-р сарын 27-ны өдрийн байдлаар Архангай аймгийн хэмжээнд нэн шаардлагатай тохиолдолд хэрэглэх түргэвчилсэн оношлуур эхний ээлжинд 1000 ширхэг байна. Нэгдсэн эмнэлэг дээр сайн дурын шинжилгээнд хамруулах цэг байнга ажиллаж байна.

Архангай аймгийн хэмжээнд 5-16 өрөөтэй 17 буудлын 298 өрөөг хүн тус бүрээр тусгаарлахаар бэлтгэсэн, мөн 3 сургуулийн дотуур байрыг тусгаарлах байраар бэлдсэн.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт**

2020 оны 11-р сард улсын төсөвт 113390.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 113390.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувиар, орон нутгийн төсөвт 914248.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 914248.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувь биелүүлэхээр ажиллаж байна.

### **Хөрөнгө оруулалт**

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 42.481.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас орон нутагт эрх шилжсэн 19.953.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 11-р сарын байдлаар 15.420.3 сая төгрөг байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжихээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнээс гүйцэтгэл нь 435.0 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжихээс гүйцэтгэл нь 1.922.0 сая төгрөг байна, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

### **Орон нутгийн өмч**

Орон нутгийн өмчит 46 төсөвт байгууллагад 80.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 7 төсөвт байгууллагад 48.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, 12 байгууллагад 358 нэр төрлийн 291.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрөл тус тус олгосон.

### **Санхүүгийн хяналт**

Эрдэнэбулган сумын 1 дүгээр сургууль, Хашаат сумын төсөвт албан байгууллагуудын 2018-2019 оны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт, ажил сайжруулах зөвлөмж өгч, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн 7 төрлийн актаар 5.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэх, төрийн албан хаагчдад нөхөн олгуулахаар шийдвэрлэлээ. Улсын байцаагчийн албан шаардлагаар 210.2 сая төгрөгийн дүн бүхий зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг чиглэл өгч ажилласан.

Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 3, 5-р сургуулиудын үйл ажиллагаанд аудит хяналт шалгалт хийгдэж тайлагнах шатандаа явж байна.

## Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

### Хууль, хяналт

"Маскаа зүүе, гараа угааа" аяны хүрээнд аймгийн Онцгой байдлын газраас төрийн болон хувийн хэвшлийн нийт 97 аж ахуй нэгж байгууллагын ажилтан албан хаагч, түрээслэгч, томоохон зах худалдааны төвүүдээр үйлчлүүлж буй 2500 гаруй иргэнд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, амны хаалт тогтмол зүүх, байгууллагуудыг амны хаалтгүй иргэдэд үйлчилгээ үзүүлэхгүй байх зөвлөмж өгч, Мэргэжлийн хяналтын хүнсний дэлгүүр, зах, шатахуун түгээх станц, эмнэлгийн байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хүн хоорондын зай барих, масктай иргэдэд үйлчлэх, гар ариутгах, гар угаах, иргэдийг маск зүүх, шаардлагагүй тохиолдолд гадуур явахгүй байх талаар 634 зөвлөмж, постер, санамж хуудсыг тарааж, Цагдаагийн газраас Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт 8 чиглэлд 36 алба хаагч, 8 техник хэрэгсэлтэйгээр 09.00 цагаас 21.00 цаг, 21.00-09.00 цаг хүртэл 2 ээлжээр, бусад байгууллагын 32 албан хаагчтай хамтран эргүүлийн үүргийг гүйцэтгэж байна.

11-р сард аймгийн хэмжээнд объектын гал түймрийн 7, иргэний хүсэлт 5, хүчтэй салхи шуурганы 1 дуудлага тус тус ирсэн байна.

Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны 89 дүгээр тушаалаар Улсын Онцгой комиссын шуурхай штабын ажлын хэсэг аймгийн Онцгой комиссын гишүүд мэргэжлийн ангийн алба хаагчдыг чадавхжуулах зорилгоор 11 дүгээр сарын 9, 10-ны өдрүүдэд "Тохиолдлын удирдлагын тогтолцоо" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Мөн аймаг, сумдын Онцгой комисс, мэргэжлийн ангийн алба хаагчдыг аймгийн Засаг даргын 2020 оны А/841 дүгээр захирамжаар баг, бүлэгт хувааж коронавирус /ковид-19/ цар тахал тохиолдсон үед хариу арга хэмжээ авах цагийн байдал 1, 2 дээр ажиллаж дадлага эзэмшсэн байна.

Онцгой байдлын газраас "Яндангаа хөөлье" аяны хүрээнд Эрдэнэбулган сумын 6 багийн нийт 1687 айл өрхөд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 1101 зөрчил илрүүлж 391 зөрчлийг газар дээр нь арилгуулсан байна.

Мэргэжлийн хяналтын газар "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тухай" Засгийн газрын 2020 оны 178, 181 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаалаар баталсан удирдамж, МХЕГ-ын даргын 2020 оны А/116, А/117 дугаар тушаалууд, аймгийн Засаг даргын 2020 оны А/837, А/840, А/841, А/842, А/843, А/848 дугаар захирамжуудын хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж байгууллагын шуурхай штабт 24 цагаар ажиллах хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж байна.

Эрдэнэбулган сумын хэмжээнд Хүнсний зах, хүнсний дэлгүүр, хүнсний үйлдвэр, ШТС, Эрчим хүч, Эх голомтын илч ХХК, Ар-Ус ундарга ХХК-ийн гүний худаг, ус түгээх байрууд, бохир ус цэвэрлэх байгууламж болон боловсролын байгууллагууд, МУБИС-ийн оюутны дотуур байр, тусгаарлах байруудад зэрэг 324 обектыг хамруулан дэмжлэгт хяналт хийж, 127 иргэн, аж ахуй нэгж, байгууллагын 50333 м2 талбайд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл хийлгүүлж, "Ар-Ус Ундарга" ХХК-ийн харьяа төвлөрсөн шугамд холбогдсон 3, эх үүсвэрийн 2 худаг, зөөврийн усан хангамжтай 12 ус түгээх байруудад хяналт хийж, ундны усны 26 дээжийг авч аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулсан байна.

Чулуут, Хайрхан, Цэнхэр, Хашаат, Тариат, Ихтамир сумдын Эрүүл мэндийн төвийн "Коронавирус халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын судалгаа"-г цахимаар, Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж буй 31 эмнэлгийн байгууллагыг хамруулж Коронавирус халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, аюултай хог хаягдлыг зайлуулах талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч 42 заалт бүхий 36 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Тусгаарлах 21 байранд хяналт шалгалт хийж, 10 тусгаарлах байрны хоол үйлдвэрлэлийн ундны уснаас дээж авч аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторийн

шинжилгээнд хамруулсан, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, цаашид шийдвэрлэх асуудлын талаар аймгийн Шуурхай штбат мэдээлэл хийсэн.

2020 оны 10-р сард аймгийн хэмжээнд 393 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 114, хулгайлах гэмт хэрэг 161, иргэдийн өмчийн гэмт хэрэг 56, малын хулгайн гэмт хэрэг 93, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 22, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 99, гэмт хэргийн илрүүлэлт 48.1 хувьтай байна.

Нийт 24143 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 23415 иргэнд 769.9 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1335.7 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 44.3 хувьтай байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 11-р сард 2651068.2 төгрөгийн мөнгөн дүн бүхий 574 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 55.4, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 41.8 байна.

Шүүхийн шинжилгээний алба 11-р сард криминалистикийн шинжилгээ 5, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 56, шүүх эмнэлгийн 51 шинжилгээ хийсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс 11-р сард дараах бүртгэлийг хийсэн байна.

#### **Иргэний бүртгэл**

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 129

Гэрлэлтийн бүртгэл - 32

Гэрлэлт цуцалсаны бүртгэл – 5

Эцэг тогтоосны бүртгэл - 2

Хүүхэд үрчлэлтийн бүртгэл - 3

Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 2

Нас баралтын бүртгэл - 52

Шинээр иргэний үнэмлэх олгосон - 48

Дахин олгосон – 41

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан –109 бүртгэл хийгдсэн байна.

#### **Эд хөрөнгийн эрхийн бүртгэл**

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 20

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 12

Худалдах худалдан авах гэрээ – 38

Бэлэглэлийн гэрээ – 2

Барьцааны эрхийн бүртгэл – 189

Өв залгамжлал – 6

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 5

Лавлагаа – 8

Бусад эрхийн бүртгэл – 8

#### **Хуулийн этгээд**

Шинээр бүртгүүлсэн – 7

Өөрчлөлт – 131

Тамганы хяналтын дугаар олгосон –7 бүртгэл хийсэн.

#### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

##### **Боловсрол**

Улс орны хэмжээнд үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 сарын 15-ны өдрийн А/151 дугаар тушаалаар хичээл, сургалтын үйл ажиллагааг 2020.11.17-ны өдрөөс 2020.12.01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоогоод байна.

##### **Соёл, урлаг**

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 28 шинэ уншигч бүртгэж, 169 ирэгсэдэд 149 ном, хүүхдийн уншлагын танхимаар 98 шинэ уншигч бүртгэж, 1104 ирэгсэдэд 1380 ном, гэрээр ном олгох үйлчилгээний нийтийн уншлагын танхимаар 9 ирэгсэдэд, 61 сонин, “Их мэдэх” танхимаар Эрдэнэбулган сумын IV цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн нийт 110 хүүхэд, 8 багшид 182 ном олгож үйлчилж номын сангийн MonKoha үүлэн технологийн программд ном шивэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд үндсэн фондын 279 нэрийн 601 ширхэг номыг шивж, бар коджуулсан байна.

Аймгийн Музей гадаад дотоодын аялагч, үзэгчдийн үйлчлүүлэх ая тухтай орчин нөхцлөөр хангах, музейн орчныг сайжруулах зорилгоор орчин үеийн стандартад нийцсэн нийтийн бие засах газрыг “Эсгэл” ХХК-иар 64 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авлаа.

Мөн аймгийн Экологийн цагдаагийн албанд аймгийн хэмжээнд байдаг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл буюу 106 булш, бунхан, хиргисүүдийн мэдээллийг гэрэл зургийн хамт хүргүүлсэн.

### **Эрүүл мэнд**

Шуурхай хариу арга хэмжээний 3 багийн 17 мэргэжилтэн, эмчлэх багийн 35 хүн, тусгаарлах байранд ажиллах 24 хүн нийт 78 эмч, мэргэжилтнүүдийг хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх тайлах дадлага сургалтыг зохион байгуулсан.

Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвүүдэд байгаа хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн судалгааг авч, ЭМС-ын А/101, А/269 дугаар тушаалын дагуу үнэлгээг хийн, шаардлагатай нөөцийн тооцооллыг гарган, Эрүүл мэндийн сайд, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, аймгийн Онцгой комисст хүсэлт уламжилан, аймгийн Засаг Даргын 2020 оны А/858 дугаар захирамжаар 268.9 сая төгрөгийн хамгаалах хувцас, тоног төхөөрөмжийн хангалт хийх санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

В гепатитын сайн дурын вакцинаар 40, тархвар судлалын заалтаар эрүүл мэндийн байгууллагын 47, эмчилгээнд хамрагдаж буй 9 нийт 96 хүнийг дархлаажуулсан.

Сумдын нийт хүн амын дунд КОВИД-19 өвчний халдварын тархалт 1 хувь, үүнээс 45 хувь нь хөнгөн, 35 хувь нь хүндэвтэр, 15 хувь нь хүнд, 5 хувь нь маш хүнд өвчлөхөөр тооцоолол хийж, сумын Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт хүргүүлэн, ор дэлгэх, эмнэлэг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

2020 оны 11-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 923 иргэн бүртгэлтэй байгаагаас 469 эмэгтэй. Шинэ ажлын байр 912, үүнээс байнгын ажлын байр 491, улирлын ажлын байр 57, түр ажлын байр 364 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 857, зуучлал 825 байна. 11-р сарын 19-ний өдрийн байдлаар 124 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй-7, бага-23, суурь-146, бүрэн дунд-561, техникийн болон мэргэжлийн анхан шатны-22, тусгай мэргэжлийн дунд-19, Дипломын бакалаврын-145 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 28 иргэнийг LMIS програмд шивж, тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 10-р сарын 31-ны байдлаар нийт 14.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 118 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14.6 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 54.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1017.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

### **Гэр бүл, хүүхэд, залуучууд**

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Монгол банкны салбартай хамтран зохион байгуулсан санхүүгийн мэдээлэл олгох сургалтад 500 сурагч, “Цахим орчин-соёлтой хэрэглээ” аянд 1000 гаруй сурагч, “Хүмүүжлийн эерэг арга” сургалтад 35

сурагч, “Гэр бүлийн боловсрол” цуврал сургалтад 18 иргэн, “Эрх үүрэг оролцоо” сургалтад 65 төрийн албан хаагч, “Цахим орчин-соёлтой хэрэглээ” аянд 250 эцэг эхийг сургалтад тус тус хамруулж, мэдлэгийг нэмэгдүүлсэн.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гишүүдэд чиг үүргийг танилцуулж, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн гэрээр эргэлт хийж, 123 хүүхэд гэр бүлд тусламж дэмжлэг үзүүлсэн.

Хүүхдийн алба, гэр бүлийн албанаас 110 гаруй удаагийн зөвлөмжийг бэлтгэж, байгууллагын пейж хуудсаар олон нийтэд түгээж, 4200 иргэдэд хүргэсэн байна.

Түр хамгаалах байранд нөхцөл байдлын үнэлгээний дагуу хүргэгдэж ирсэн 5 хүүхдэд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлж, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд холбон зуучилсан.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

#### **Мал аж ахуй**

Малчдын түвшинд 80.0 мянган тн өвс 1300 тн тэжээл болон бусад нэмэгдэл тэжээл хужир шүүг бэлтгүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс өөрийн аймгийн болон Төв, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Увс зэрэг аймгуудын нутгаас малчдын түвшинд 50.0 мянган тн өвс, 2681 тн ногоон тэжээл, 1155 тн гар тэжээл, 6.8 тн үйлдвэрийн тэжээл, 98.6 тн давс хужир шүүг нөөцлөн аваад байна. Тэжээл бэлтгэл 70 орчим хувьтай байна. Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймгуудаас иргэд 20.0 мянган боодол буюу 40 гаруй тн өвсийг авч ирэн 9.0-12.0 мянган төгрөгөөр худалдан борлуулж байна.

Засгийн газрын тогтоолын дагуу 2020 онд аймгийн аюулгүй нөөцөд 1200 тн өвс, 200 тн тэжээл, сумдын нөөцөд 5700 тн өвс, 1330 тн тэжээл бэлтгэхээр төлөвлөсөн. Хангай, Тариат, Эрдэнэмандал, Булган, Цахир, Эрдэнэбулган, Өндөр-Улаан, Хайрхан сумдын аюулгүй нөөцөд 465.2 тн өвс, 89.2 тн тэжээл бэлтгэн нөөцөлсөн байна.

### **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

#### **Хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон аймгийн Онцгой комиссод хүнсний нөөцийн мэдээг 7 хоногт 2 удаа гаргаж мэдээллээр ханган ажиллаж байна. Сүүлийн 7 хоногийн судалгаагаар мах 141.6 тн буюу 11 хоног, гурил 230.7 тн буюу 30 хоног, гоймон 33.2 тн буюу 2 хоног, будаа 87.4 тн буюу 23 хоног, сахар 51.3 тн буюу 21 хоног, ургамлын тос 18 тн буюу 10 хоног, давс 30.5 тн буюу 76 хоног, ундны ус 18.2 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 4.5 тн буюу 3 хоног, төмс 243.9 тн буюу 30 хоног, хүнсний ногоо 40.1 тн буюу 4 хоног, өндөг 1.3 тн буюу 22 хоногийн нөөцтэй байна.

#### **Барилга, дэд бүтэц**

Архангай аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр 79 тэрбум 378.9 сая төгрөгийн өртөг бүхий 41 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр 955.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ, БСШУС-ын сайдын багцын 1 тэрбум 703.6 сая төгрөгийн өртөг бүхий 22 төсөл арга хэмжээ, нийт 82 тэрбум 37.5 сая төгрөгийн өртөг бүхий 71 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----